



Ражив Гангийн нэрэмжит
Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж


2023

СУРАЛЦАГЧДЫН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ
ИЛТГЭЛҮҮД



АГУУЛГА

1. Суралцагч төвтэй арга зүйг сайжруулах оюутны оролцоо- Г. Анударь
2. Хуванцар савны хэрэглээ, бидний ирээдүй – Э.Энхжаргал
3. Номтой нөхөрлөө клуб байгуулах нь -Э.Оюун-Эрдэнэ, Б.Ариунзул
4. Байгууллагын үйл ажиллагаанд НБД-ын үүрэг оролцоо- Э.Лхагвадолгор
5. Бидний хүрээлэн буй орчинд тулгамдаж байгаа асуудал-Б.Анужин, Т.Цэнгэл



ИЛТГЭЛИЙН СЭДЭВ
БИДНИЙ ОРОЛЦОО-БИДНИЙ ИРЭЭДҮЙ
СУРАЛЦАГЧ ТӨВТЭЙ АРГА ЗҮЙ - ОЮУТНЫ ОРОЛЦОО

ОРШИЛ

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдрал, насан туршид нь нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн гол түлхүүр тул иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн, чанартай боловсрол эзэмших нь хувь хүний үндсэн үүргийн нэг. Хүн бүр боловсрол эзэмшсэнээр өсөж дэвжин, амьдралынхаа эзэн, хөгжлийн бүтээгч нь болдог (**“Боловсролын хүүрнэл” гарын авлагаас**)¹.

Хүн төрсөн цагаасаа нас эцэслэх хүртлээ тасралтгүй суралцаж байдаг хэдий ч бага насанд эзэмшсэн дадал, хандлага, үндсэн ойлголтуулаас тухайн хүний амьдралын чанар, цаашлаад нийгэмд хүртэл асар их өөрчлөлт үзүүлдэг. Өөрөөр хэлбэл ирээдүй ямар байх нь хүмүүсийн боловсролын түвшин болон түүнд хандах хандлага, шинжлэх ухаанч сэтгэлгээ байгаа эсэхээс ихээхэн хамаарна.

Бид боловсролыг олон нийтэд түгээх, хойч үедээ өвлүүлэхийн тулд сургалтын хөтөлбөр, заах арга аргачлал боловсруулж, түүгээрээ мэдлэгийг аль болох жигд, хүртээмжтэй олгохыг хичээдэг. Гэвч багшийн заах арга туршлага, ур чадвар, суралцагч бүрийн суурь зан чанар, хүсэл эрмэлзэл, суралцах орчны ялгаатай байдлаас шалтгаалж тэнцүү хэмжээний мэдээлэл хүлээн авч чадахгүй байх асуудал тулгарч байна. Нэг багш хичээлийн 40-80 минутын хугацаанд дунджаар 30-40 хүүхдэд тус бүрийн суралцах ялгаатай байдалд нь тохируулж бүтэн агуулгыг бүрэн, жигд ойлгуулна гэдэг тун ч ярвигтай асуудал билээ. Үүнээс гадна, суралцагчид өөрсдийн сурахуйн онцлогоос ичих, шүүмжлүүлэхээс айн чөлөөтэй асуулт асууж чадалгүй явсаар хоцрогдолд орж, эндээс боловсролын ялгаа үүсч, ирээдүйд сөрөг үр дүн гарч болох талтай.

Энэ бол дан ганц хэн нэг багшийн, эсхүл ямар нэг боловсрол олгох байгууллагын асуудал биш, суралцаж буй оюутан суралцагчдын ирээдүйтэй нягт холбоотой зүйл учраас бидний зүгээс ч мөн хүчин чармайлт гаргах хэрэгтэй юм. Иймээс миний бие оюутны нүдээр энэхүү тулгамдаад буй асуудлын мөн чанар, шалтгааныг тодорхойлж, гарц шийдэл эрэлхийллээ.

СЭДЭВ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

БАГШ-СУРАГЧ чиглэлтэй харилцаа үүсэх үед дээр дурдсанчлан багшид ч сурагчид ч ямар нэг байдлаар бэрхшээл учирдаг. Дүрсэлж хэлбэл багш болон ангийн хойно сууж хичээллэж буй хүүхдүүдийн хооронд үл үзэгдэх “хана” үүсдэг ч гэж ойлгож болно. Гэтэл багш тэдэнд хүрч ерөнхий агуулгаа ойлгуулж амжилгүй хичээлийн цаг дуусах энэ үзэгдлийг та дурын нэг ангид ороход харж болохуйц байна. Үүнтэй багшийн **заах аргаас** гадна суралцагчийн өөрийн **суралцах арга** гүйцэд хөгжөөгүй байдал ч холбоотой.

Тэгвэл бид энэ орчин уур амьсгалаа илүү тухтай болгохын тулд **СУРАГЧ-СУРАГЧ** буюу сурагчид нэгэндээ нөлөөлөх, шүүмжлэлгүй орчинд мэдлэгээ дээшлүүлэх, бусдаасаа үлгэр дуурайлал авч өөрийн сурах аргаа олох, төлөвшүүлэх боломжийг олгох хүрээллийг бий болгох нь үр дүнтэй байж болох юм.



Тэгвэл бид энэ аргачлалыг хэрхэн зохион байгуулах вэ? Эргэн тойрны хүмүүстээ оюутны зүгээс хэрхэн нөлөөлж тэрхүү аюулгүй уур амьсгалыг бүрдүүлж чадах вэ? Практикт ийм сургалтын арга үр дүнтэй байж чадах эсэх, цаашлаад нийт суралцагчдын сурлагын амжилтанд нөлөөлөх эсэх талаар судалгаа хийж, санал дэвшүүлэхээр шийдлээ.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Зорилго: Суралцагчид нэгэндээ туслах, нөлөөлөх арга зүй боловсруулах замаар тэдний тус бүрийн сурах арга барилд тохируулан боловсрол олгож хүртээмжийг сайжруулах

Зорилт:

- Сургалтын явцад суралцагчдад болон багш нарт тулгамдаад буй асуудал, түүний шалтгааныг тодорхойлох
- Гарц шийдлийг эрэлхийлэн бодит кэйс, судалгааны үр дүнд задлан шинжилгээ хийх
- Уламжлалт сурах/сургах арга барилын давуу болон сул талыг тодорхойлж, шинэ шийдэл, арга зүйг боловсруулах

Ач холбогдол

- ❖ Суралцагчдын боловсролд хандах хандлага сайжирч, идэвх нэмэгднэ
- ❖ Илүү чанартай мэдлэг олж авахад, түгээхэд дөхөм болно
- ❖ Сурах арга барилаа олж чадахгүй байгаа суралцагчдад тусалснаар сурлагын амжилтыг нь ахиулах зэрэг ач холбогдолтой.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ



- ❖ Онолын судалгаа (мэдлэг олгох, эзэмших арга барилууд, тэдгээрийн нийлэмж, уялдаа холбоо, хувь хүний төлөвшил боловсролд хандах хандлагад хэрхэн нөлөөлөх талаар ойлголт авах)
- ❖ Туршлага, жишээг судлах (СУРАГЧ-СУРАГЧ аргыг ашиглан хичээллэдэг багш сурагчдын туршлагыг судлах, хичээлийн үед гарч буй эерэг болон сөрөг үр дүнг ажиглаж, БАГШ-СУРАГЧ чиглэлтэй харьцуулан дүгнэх, сайн жишээг дэлгэрүүлэх)
- ❖ Санал асуулга, ярилцлагын судалгаа (нийт багш нар болон суралцагчдаас сургах, суралцах арга барилын талаарх судалгаа авч, түүвэрлэн ярилцлага авч судлах)

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Онолын судалгаа

Хүний боловсролын түвшинд хүүхдийн хүмүүжил төлөвшил шууд нөлөөлдөг билээ. Ширазын Анагаахын шинжлэх ухааны их сургуульд хийсэн корреляцийн судалгаагаар 1600 оюутнаас 310 оюутныг санамсаргүй байдлаар сонгон авч суурь хүмүүжлийн онцлог болон сурлага, карьерийн амжилтын талаарх судалгааг авч үр дүнг харьцуулахад хүүхдийн гэр бүлийн, анги хамт олны уур амьсгал, хүүхэдтэй шууд, тогтмол харьцдаг насанд хүрэгчидтэй (эцэг эх, багш г.м) харилцах харилцаа болон тухайн хүүхдийн бүтээлч байдал, хандлагын түвшинтэй мэдэгдэхүйц холбоотой, эцэг эхтэйгээ тааруу харилцаатай хүүхдүүд халуун дулаан уур амьсгалтай гэрт амьдардаг хүүхдүүдээс сурлагын амжилтын хувьд илүү байна гэсэн ерөнхий үр дүн үзүүлжээ. Мөн Тегеран хотын ахлах сургуулийн 3-р ангийн сурагчдын өөрийгөө үнэлэх үнэлэмж, урам зориг ба боловсролын амжилтын хамаарлыг судалжээ. Судлаач өөрийгөө үнэлэх чадвар, амжилтын сэдэл, боловсролын амжилт гэх 3 ойлголтын хооронд мэдэгдэхүйц хамаарал байгааг олж мэдсэн байна. (эх сурвалж: <https://www.ncbi.nlm.nih.gov>)²

Дээрх судалгааны үр дүнгээс харахад, хүний боловсролын талаарх үзэл бодол нь уур амьсгал, хүн хоорондын харилцаа, өөрийгөө үнэлэх үнэлэмж зэргээс шалтгаалж өөрчлөгддөг гэдгийг тодорхой харж болно. Тэгвэл бид хэдийн харилцаа сайтай, “хана” үүсээгүй хүмүүс буюу сурагчийг сурагчаар нь багшлуулах, хөгжүүлэх аргачлалыг илүү албан ёсны, боловсронгуй байдлаар зохицуулан сургалтдаа ашиглах хэрэгтэй гэж үзлээ.

САНАЛ АСУУЛГА БОЛОН ЯРИЛЦЛАГЫН СУДАЛГАА

Үйлдвэр Урлалын Политехник Коллежийн багш, оюутнууд дунд тэдний сурах/сургах арга барилыг судлах, суралцах явцад ямар төвөгшил гарч байгааг тодорхойлох зориолготой санал асуулга явуулав.

Багш нарын судалгаанд нийт 22 багш хамрагдсанаас 63.6% нь мэргэжлийн боловсролын, 36.4% нь ерөнхий эрдмийн боловсролын багш байсан бол суралцагчдын судалгаанд нийт 129 суралцагч оролцсоноос 61.7% мэргэжлийн боловсролын 2.5 жилийн, 12.5% нь 1 жилийн анги, 10.9% нь техникчийн боловсролын 3 жилийн, 14.8% нь 1.5 жилийн ангид суралцдаг оюутнууд хамрагджээ.

Та дараах арга барилуудаас алийг нь өөртөө тохирсон гэж үздэг вэ? (нэгээс олон хариу сонгож болно)

126 responses




График 1. Сурах арга барилын давтамжын судалгаа

Оюутнуудын дунд ямар сурах арга илүү олонхыг хамарсныг судлахаар санал асуулга явуулахад 62 саналаар сонсголын арга буюу аливаа судлагдахууныг бусдаар тайлбарлуулж, ярилцсаны үндсэн дээр ойлгодог, үүний араас бие даан турших, бүтээх, зураг видео үзэх зэрэг аргаар суралцдаг гэсэн үр дүн гарсан. Мөн тэднээс ярилцлагын аргаар сурах аргыг хөгжүүлэх, боловсролыг илүү хүртээмжтэй болгохын тулд бид юу хийх шаардлагатай талаар ярилцсаны дүнд:


- Хүүхэд бүрийн сурах аргад тохирсон байдлаар хичээллэх
- Сурагчдад төвлөрч, хичээллэж болох орчинг бүрдүүлэх, сонгоны давтлага, дугуйлан хичээллүүлэх
- Хичээлийн үеэр сурагчид өөрсдийн ойлгоогүй зүйлээ бусдаас асуух, хичээлийн агуулгын талаар ярилцах цаг гаргах
- Багш нарын заах аргыг сайжруулах гэх мэт саналуудыг хүлээн авсан.

Суралцагчдын хүсэл эрмэлзэл, боловсролын талаарх үзэл бодол ямар түвшинд байгааг олж мэдэхийн тулд google forms программаар санал асуулга явуулахад:

График 2. Сонирхолын судалгаа


Та хичээлдээ дуртай юу?

128 responses



Таны хувьд боловсрол хэр чухал вэ?

129 responses



“Та хичээлдээ дуртай юу” гэсэн асуултад 57.8% тийм, 11.7% нь үгүй, 30.5% нь цөөн хэдэн хичээлд л дуртай гэж хариулснаас харахад судалгаа бөглөлчдийн талаас илүү хувь нь сурахад дур сонирхолтой байгаа ч үлдсэн тал нь эсэргээрээ буюу хичээл хийх сонирхолгүй, эсвэл өөрийн дуртай, сайн хийж чаддаг хичээлээ л хийдэг гэдэг нь ажиглагдаж байна.


График 3. Хандлагын судалгаа

“Таны хувьд боловсрол хэр чухал вэ?” гэсэн асуултад 57.4% нь маш чухал, 14% нь тийм ч чухал биш, 26.4% нь чухал гэж боддог ч зарим бэрхшээлүүдээс болж шантарсан гэсэн хариуг илгээсэн. Өмнөх асуулттай адил талаас илүү хувь нь сурах хүсэл эрмэлзэлтэй, боловсролд хандах хандлага нь эерэг байгаа нь сайшаалтай ч үлдсэн суралцагчид мөн адил эерэг үзэл бодолтой хэрнээ сурах сонирхолоо алдсан, шантарсан байна. Үүний шалтгааныг дараа дараагийн асуултуудаар тодруулахыг хичээлээ.

График 4. Шалтгааныг тодорхойлох нь

Багш нарын заах аргын онцлог, харилцаанаас шалтгаалж тухайн хичээлийг судлах хүсэл сонирхол буурах тохиолдол гардаг уу?

130 responses



“Багш нарын заах аргын онцлог, харилцаанаас шалтгаалж тухайн хичээлийг судлах хүсэл сонирхол буурах тохиолдол гардаг уу?” гэсэн асуултад 66.9% нь тийм, 33.1% нь үгүй гэж хариулснаас харахад багш төвтэй сургалт цөөнх сурагчдад л үр дүнтэй байдаг бөгөөд үүний гадна үлдсэн суралцагчид тухайн хичээлдээ бүрэн ойлголт авч чадалгүй хоцрогдох, улмаар хичээлдээ дургүй болох үр дүн гарч буй.


Нөгөө талаас нэгж хичээлд хүүхэл бүр ижил түвшний боловсрол авч чадахгүй байгаагийн нэг баталгаа нь

Санамсаргүй байдлаар сонгон авсан багш нараас ярилцлагын аргаар хичээл заахдаа ихэвчлэн сургалтын ямар аргуудыг ашигладаг талаар лавлахад кейс дэвшүүлэн шийдвэрлэх, KWL, практик үйлийн арга, хосоор ажиллуулах г.м аргуудыг түлхүү ашигладаг гэжээ. Мөн сургалтын чанарыг сайжруулахад юу хийх нь илүү оновчтой талаарх асуултанд:

- Суралцагчдын давуу тал, онцлогийг тодорхойлж өөрсдийнхөөрөө хөгжих боломжыг олгох
- Оюутнуудын сурах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, ухамсарлуулах
- Нээлттэй дугуйлан, клуб ажиллуулж, бие даан хичээллэх орчныг бүрдүүлж өгөх гэх хариултууд ирсэн.

Та ээлжит хичээлээ төлөвлөхдөө тухайн ангийн суралцагчдын сурах арга барилд тохируулан өөр өөр аргаар заахаар төлөвлөдөг үү?

22 responses



Хичээл орж буй ангийн суралцагчдийн хэдэн хувь нь идэвх санаачлагатай оролцдог вэ?

22 responses




График 5, 6. Багш нараас авсан судалгаа


Google forms программаар санал асуулга явуулж “Та ээлжит хичээлээ төлөвлөхдөө тухайн ангийн суралцагчдын сурах арга барилд тохируулан өөр өөр аргаар заахаар төлөвлөдөг үү?” гэх асуултанд хамгийн их буюу 36.4% нь “ихэнхдээ” гэх хариулт өгснөөс харахад багш нар суралцагчдын ялгаатай байдал, сурахуйн онцлогт мэдрэмжтэй хандахыг хичээж, тэдэнд тохируулж өөр өөр заах аргыг ашигладагийг харуулж байна.

Гэвч “хичээл орж буй суралцагчдын хэдэн хувь нь идэвх санаачлагатай оролцдог вэ?” гэсэн асуултад 50% нь “40-60%”, 31.8% нь “70-90%”, 18.2% нь “10-30%” нь идэвхтэй оролцдог гэсэн хариу ирүүлсэн нь хэдий багш заах аргаа өөрчилж хичээллэсэн ч нэг удаад нэг л аргаар заах учир тухайн ангийн хүүхдүүдийн талд нь л үр дүнгээ өгч чадаж байгааг харж болно. Уламжлалт сургалт нь хүүхдэд хоцрох мэдрэмж өгдөг, бусадтай харьцуулагдах мэдрэмж өгдөг, цагт шахагдсан мэдрэмж өгдөг, улмаар хичээл бол дарамт, ачаа мэт ойлголт өгснөөр хичээлгүй үедээ л жаргалтай

байх юм гэсэн сэтгэлзүй рүү хөтөлж байна. Ингэж л суралцагч болон багш хоёрын хооронд “хана” үүсч, ойлголцоход төвөгтэй нөхцөл байдал үүсдэг ажээ.

Олон хүүхэдтэй ангид хичээл заахад танд ямар ямар бэрхшээл учирдаг вэ?

21 responses



“Олон хүүхэдтэй ангид хичээл заахад танд ямар бэрхшээл учирдаг вэ?” гэсэн асуултад хамгийн олон санал авсан хариулт нь “хичээлийн дараа бүх хүүхдүүд жигд ойлголт авч чадаагүй байдаг” гэсэн хариулт 14 саналтайгаар тэргүүлж байсан бол “хоцрогдолд орсон, хичээлээ ойлгоогүй хүүхдүүдтэй тулж харьцахад хүндрэлтэй байдаг”, “суралцагчид асуулт тавьдаггүй, хичээлд идэвхгүй оролцдог” гэх хариултууд удаалжээ. Энэ нь багш төвт сургалтын явцад багш, сурагч аль алинд нь бэрхшээл хүндрэл үүсч байгааг харуулж байна.

ТУРШЛАГА, ЖИШЭЭГ СУДЛАХ

Олон улсад сүүлийн жилүүдэд мөн л суралцагч бүрийн сурахуйн онцлогт тохируулан **Train the trainer** буюу сургагч багшийн стратегийг хөгжүүлэх хандлагатай байгаа юм. Угаас энэ аргачлал цоо шинэ зүйл биш, сургалтын явцад их бага хэмжээгээр хэрэгжиж, үр дүнгээ өгч байсан зүйл. Калифорнийн сангаас явуулсан "Сургагч багшийг сургах" загварт хийсэн нэг дүн шинжилгээ нь уг загвараар хичээлийг зохион байгуулахад бүх оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин ерөнхийдөө өндөр, тэр дундаа сургалтанд хамрагдаж буй хүмүүсээс илүү сургагч багшийн хувьд эрс дээшилсэн үзүүлэлттэй байжээ.



Суралцагч: Г.Анударь

СУРАЛЦАГЧ ТӨВТЭЙ АРГА ЗҮЙ - ОЮУТНЫ ОРОЛЦОО

Аргачлалын нэг шүүмжлэлтэй тал нь дээрээс доош чиглэсэн заах арга юм. Тухайн хичээлийг сурагч сурагчдаа заах, багш нэгэн зэрэг бусдад нэг хичээл заах хоёрын цагийн хуваарилалтад үүсч буй төвөгтэй байдал нь оролцогчид өөрийгөө илэрхийлэх, эсвэл суралцагчдад хичээлийн ойлголтыг сургагч сурагчид өөрсдөө ойлгоод бусаддаа заах зэрэгт хязгаарлагдмал хэмжээний хичээлийн цаг үлдээдэг. Энэ загварыг ашигладаг олон хичээл нь интерактив үйл ажиллагаануудыг агуулдаг боловч үндсэндээ лекц хэлбэрээр зохион байгуулагдсан байдаг. (Эх сурвалж: <https://work.chron.com/train-trainer-model-5463.html>)³

Энэ судалгаанд СУРАГЧ-СУРАГЧ чиглэлтэй арга барилын давуу болон сул талыг тун оновчтой тодорхойлжээ. Энэ нь хүүхдийн "чадахуйц төвшин"-г тодорхойлж, тэрхүү цэгээс "өөрийн хурд"-аар тайван хичээлээ хийх боломжийг олгож, мөн "нэг төрлийн даалгавар"-аа бүрэн гүйцэт алдаагүй, ажрахгүй, хөгжилтэйгөөр урагшлах боломжийг олгодгоороо давуу юм. Практик дээр харин энэ аргыг урт хугацаанд хэрэгжүүлэх үед гарах үр дүнг бодит жишээнээс харж болох юм.

Математикийн багш Оюунгэрэл нь 2020-2022 оны хооронд суралцаж байсан Оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлийн 2 бүлэгт математикийн хичээл заасан. Хичээл заах арга барил нь дээрх сурагч сурагчдаа туслах ерөнхий стратегийг баримталсан, багш хичээлийн ерөнхий мэдэгдэхүүнийг өгсний дараа дасгал ажиллуулж, хичээлийг ойлгосон суралцагчдыг бусаддаа туслахыг уриалах үндсэн стратегийг ашиглаж, үүнийгээ хэд хэдэн удаа давтах замаар хүүхдүүдэд шаталсан байдлаар судлагдахууны агуулгыг хүргэдэг онцлогтой.

1-р курс буюу ийм аргачлалаар хичээллэж дөнгөж эхэлж байх үед өөр өөр газраас нэг ангид цугласан, янз бүрийн түвшинд сурах арга нь хөгжсөн, танилцаад удаагүй хүүхдүүдэд ийм арга эхэндээ эвгүй, хичээл зааж буй суралцагчийн тоо цөөн, бусдадаа тайлбарлах нь хэцүү санагдаж байсан ч энэ аргачлал хүүхдүүдийг нийгэмших, дотносоход түлхэц үзүүлж байсан бөгөөд хоцрогдолд орсон суралцагчдад хичээлээ дахин эхнээс нь судлах боломжийг олгож, шүүмжлэлээс айлгүйгээр асуулт асуух чөлөөтэй орчинг бүрдүүлж чадсан. Мөн цахим сургалтын үед хүүхдүүдийн идэвх оролцоо харьцангуй их буураагүй нэг шалтгааныг ч үүнтэй холбож болох юм.

2-р курст орох үед энэ сургалтаас эерэг үр дүн ажиглагдаж эхэлсэн. Ихэнх суралцагчдын хоцрогдол арилж, сурах хүсэл эрмэлзлээ эргүүлэн олж авч байсан бөгөөд бусдадаа тусалдаг сурагчдын тоо эрс дээшилсэн. Суралцагч хоорондын болон багштай харилцах харилцаа илт сайжран идэвх оролцоо нь нэмэгдсэн. Харин энэ үед хичээлийн шахуу хуваарь болон тухайн аргачлалын онцлогоос шалтгаалж суралцагчдад ачаалал ихээр ирж байлаа.

Суралцагч: Г.Анударь

СУРАЛЦАГЧ ТӨВТЭЙ АРГА ЗҮЙ - ОЮУТНЫ ОРОЛЦОО

ҮР ДҮН



Ийнхүү 2 жилийн турш СУРАГЧ-СУРАГЧ аргаар хичээллэсний үр дүнд суралцагчид илүү бие даан суралцаж, өрсөлдөж, нэгэндээ тусалсаар сурагч нэг бүр сургалтын арга барилаа эзэмшиж маш амжилттайгаар төгссөн. Дадлагажуулагч байгууллагууд мөн сурах хүсэл эрмэлзэлтэй, тууштай, хариуцлагатайгаар суралцаж чадаж байсан, сургуулиа төгссөний дараа урилга авч ажиллах дадлагажигчдийн тоо өсөлттэй байсан талаар хэлж байлаа. Суралцагчидтай ярилцах үед тэд өөрсдийн ахиц дэвшилдээ сэтгэл ханамж өндөр байсан нь тод томруун харагдаж байв.

“Өмнө нь надад миний үе тэнгийн хүүхдүүд надаас илүү, би хэзээ ч тэднийг гүйцэж чадахгүй гэж боддог, мэдлэггүйгээсээ ичдэг байлаа. Харин шинэ орчинд багшаасаа, найзуудаасаа үлгэр дуурайлал авч суралцсанаар өөртөө илүү итгэлтэй болсон. Одоо хаана ч очсон нүүр улайхгүй суралцаж, хөгжиж чадахаар болсондоо баяртай байна.”

Ц. Сонгууль 18 настай, эмэгтэй

Зөвхөн энэ жишээ л гэхэд нэг хүний зөв хандлага, тунг нь тааруулсан оновчтой сургалтын арга зүй энэ олон хүнд эерэгээр нөлөөлж, сурах аргаа олсон суралцагчдын ирээдүйд хэрхэн эерэг нөлөө үзүүлж байгааг харж болно. Бүх хичээлд 100% энэ аргыг нэвтрүүлэх боломжгүй ч багшийн зүгээс ч, суралцагч бидний зүгээс ч хичээл зүтгэл гаргаж сурагч сурагчдаа заах аргыг илүү дэлгэрүүлэх хэрэгтэй юм.

ДҮГНЭЛТ



Судалгааны үр дүнгээс авч үзэхэд, сургалтын чанарыг сайжруулахын тулд бидний эн тэргүүнд хийх шаардлагатай арга зам бол суралцагч төвтэй, тэдний бие даан хөгжих боломжыг олгохуйц нөхцөлийг бий болгох билээ. Багшаас ирж буй шинжлэх ухааны суурьтай нэг том агуулгыг багш өгч, харин түүнээс ойлгоогүй хэсгийг СУРАГЧ- СУРАГЧ стратегийн дагуу ойлгосон сурагчид нь илүү ойлгомжтой, хялбар байдлаар зааж өгдөг, ингэснээр суралцагч бүр өөрсдийн арга барилаар мэдлэг олж авах аргачлал нь үр дүн ихтэй бөгөөд олон улсын

түвшинд сурагч төвтэй сургах/суралцах аргыг хөгжүүлж, тэр чигт аажмаар хувьсаж байна. Цаг хугацаа ихээр шаардагддаг, ачаалал их энэ аргачлалд хүүхдүүд дасан зохицоход хүндрэл үүсч болох ч эцсийн дүнд сурагчдын сэтгэл ханамж өндөрсч, сэтгэлд нь сурах хүсэл эрмэлзлийн гал нэгэнт ассан үед ямар ч хүн ямар ч нөхцөлд хэдий хэмжээний ч ачааллыг үл ажран суралцаж чадах юм. Сурган хүмүүжүүлэгчид нэг талаас удирдан зааж зөвлөж, оюутан суралцагч бид нөгөө талаас илүү нээлттэй сэтгэлгээгээр бие биедээ тусалж, өрсөлдөж, нэгнийхээ сэтгэл дэх галыг асааснаар суралцагч нэг бүр “боловсрол” хэмээх гайхамшигт ертөнцөд хөл тавих зориг, хүчийг олж чадах буй заа.

НОМ ЗҮЙ

1. “Боловсролын хүүрнэл” гарын авлага;¹
2. Shiraz University of Medical Sciences, Shiraz, Iran;²
3. <https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC4927255/>
4. <https://work.chron.com/train-trainer-model-5463.html>³



ИЛТГЭЛИЙН СЭДЭВ

ХУВАНЦАР САВНЫ ХЭРЭГЛЭЭНД БИДНИЙ ОРОЛЦОО

ЗОРИЛГО

Хуванцар савны хүн болон байгаль орчинд үзүүлж буй хор хөнөөлийн талаар, хуванцар саван дээрх тэмдэглэгээг таньж сурах ба сурагчдын хуванцар савны хэрэглээг судалж, нэгтгэн дүгнэж танах аргад суралцахад оршино.

ЗОРИЛТ

1. Хуванцар савны хор хөнөөл болон тэмдэглэгээний тухай мэдэж авах.
2. Оюутан суралцагчдын хуванцар савны хэрэглээг тандан судлах.
3. Судалгаанд үндэслэн дүгнэлт хийж шийдвэрлэх боломжийг эрэлхийлэх.

ҮНДЭСЛЭЛ

Манай улсад зориулалтын бус хуванцар савын олноос их, үнэ хямд зэргээс шалтгаалан айл өрхүүд ундны ус, сүү, айраг зэрэг хүнсний шингэн бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэхэд өргөнөөр хэрэглэж байна. Хуванцар савны тэмдэглэгээ, эрүүл мэндийн нөлөөлөл, зохистой хэрэглээний талаарх мэдлэг дутмаг байгаа учраас заавалчгүй танин мэдэх шаардлагатай.

СУДАЛГААНЫ АРГА

- ✓ Асуулгын арга /Google form /
- ✓ Ажиглалтын арга
- ✓ Нэгтгэн дүгнэх арга

ХУВАНЦАРТ ХҮЛЭГДСЭН АМЬДРАЛ



Муу л гэх юм билээ, хэн мэдэх вэ. Одоо ч тэгээд муугүй юм байхаа болио шив", "Хэрэглэхгүй гээд яалтай билээ". хөдөөгийн малчин айлын гэрийн эзэгтэйгээс хуванцар савны хор уршиг, сөрөг үр дагаврын талаарх бодлыг асуувал ийм бүүр, түүрхэн хариулттай сууна. Гэр

доторх сүүний шанага, айргийн бүлүүр, хөхүүр, саамын хувин. Тун саяхан төхөөрсөн хонины гэдэстэй сав гээд ахуйн хэрэглээний олон суулга хуванцар байх аж. Харин гэрийн гаднах устай савнууд бүгд эчнээ БИДНИЙ танил "25-ын шарууд" байна. ИНГЭЭД Л ХАРАХАД БИД ӨДӨР ТУТАМДАА хуванцрыг хэрэглэж хордож байгаа нь яалт ч үгүй.

ХУВАНЦАР МАТЕРИАЛЫН ТҮҮХ

Анх 1907 онд Лео Баеклэнд нээж байсан түүхтэй. Хуванцар нь синтетик болон байгалийн өндөр молекулын нэгдлээс гаргаж авсан материалыг хэлнэ. 1920-иод оны сүүлчээс АНУ хуванцарыг хэрэглээний зориулалтаар үйлдвэрлэж эхэлсэн. Хуванцрыг гаргаж авахад химийн 4000 гаруй төрлийн бодис хольдог ажээ.

ХУВАНЦАР САВНЫ ТЭМДЭГЛЭГЭЭ




PET/PETE – ундаа, ус, ам зайлах шингэн, ургамлын тос зэрэг хүнсэнд хэрэглэдэг, дахин ашиглаж болдог, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө маш бага.
HDPE- сүү, тараг, жүүс болон угаалгын нунтаг, шампунийг савладаг, дахин ашиглаж болдог, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө бага.
V/PVC- нунтаг бодис, биеийн шингэн саван, шампунь, хуванцар тавилга зэргийг хийдэг, халаах болон шатаахад агаарт диоксин ялгардаг тул хүнсэнд хэрэглэдэггүй.
LDPE- сав, баглаа, боодол, хоол хадгалах сав, тавилга, хивс зэргийг хийдэг, дахин ашигладаггүй, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө бага.
PP- тараг, жүүс, витамин, эм бэлдмэл савладаг, дахин ашиглаж болдог, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө бага.
PS – ахуйн хэрэглээний хувансар сав хийдэг, дахин ашигладаггүй.
OTHER – шүдний эмчилгээний багаж, нягтрал бүхий зарим хуванцар эдлэл хийдэг. Зарим төрөл нь аюултайд тооцогддог.

Судалгаанд Үйлдвэрлэл Урлалын Политехник коллежийн нийт 62 оюутан хамрагдсан

1. Та хэдэн настай вэ?


62 хариулт



Судалгаанд 15-17 насны суралцагчид түлхүү хамрагдсан байна.

2. Таны хүйс?


62 хариулт



Хүйсийн хувьд 67.7 хувь нь эмэгтэй, 32.3 хувь нь эрэгтэй суралцагчид хамрагдсан байна.

3. Та ямар усны сав хэрэглэдэг вэ?

62 хариулт




Судалгааг харвал нийт 62 суралцагчдын тал нь буюу 50% нь өдөр тутамдаа хуванцар усны сав хэрэглэдэг гэх үр дүн гарсан байна.

5. Таны хуванцар савны хэрэглээ хэр их гэж боддог вэ?


Хуулах

62 хариулт



Нийт судалгаа өгөгчдын 41.9% нь дундаж, 33.9% нь бага зэрэг, 21% нь маш их хэрэглээтэй гэсэн судалгаа өгсөн байна.

Нийт судалгаа өгсөн: 62 хүн




Хамгийн их хувь эзэлсэн нь хоолны халуун сав болон зөөврийн сав гарсан бөгөөд түүний дараагаар ундны ус зөөвөрлөдөг 25-30литрийн шар болон цэнхэр сав хэрэглэдэг гэсэн байна.

7. Та хуванцар сав юунаас бүрддэгийг мэдэх үү?

Хуулах


62 хариулт



Судалгааг харж үзвэл суралцагчдын дунд хуванцар савны хэрэглээ, мэдлэг, хэрхэн ахуйн хэрэглээндээ ашиглах талаар ойлголт хомс байгааг харуулж байна.

Та гэр ахуйн хэрэглээний хуванцар сав авахдаа юуг нь харж авдаг вэ?


Судалгаанд оролцсон нийт хүн: 96



Иргэд хуванцар сав худалдан авахдаа тэмдэг тэмдэглэгээнээс илүү үнэ болон гадаад үзэмжийг илүү түлхүү харж авдаг байх нь. Энэ нь ард иргэдийн эдийн засагтай шууд холбоо хамааралтай гэж бодож байна. Мөн хуванцар савны тэмдэг тэмдэглэгээны талаарх мэдлэг дутмаг байгааг харуулж байна.

10. Хуванцар савнаас татгалзахад хамгийн үр дүнтэй аргыг аль нь гэж та бодож байна? Хэдэн ч хариулт сонгож болно.

62 хариулт



Хуулах

Судалгааны үр дүнд олон удаа ашиглаж болох төмөр болон шилэн сав суулга хэрэглэх нь хуванцар сав суулганаас татгалзах хамгийн боломжтой арга гэсэн үр дүн гарсан байна. Түүний дараагаар нийт суралцагчдын 34% нь хуванцар материалын төрөл ангиллыг таньж мэдэх нь мөн чухал үр дүнтэй гэж үзсэн байна.

Шийдвэрлэх арга зам

УИХ, ТӨР ЗАСАГ

1. Ахуйн хэрэглээнд ашиглаж буй хуванцар савны тэмдэг тэмдэглэгээн дээр хяналт тавих.
2. Хууль баталж хэрэгжүүлэх
3. Хилээр орж ирэхэд хязгаарлалт хийх.

Сургууль

1. Суралцагчдад хуванцар савны мэдлэг, ойлголтын талаар хими, биологийн хичээлээр дамжуулан түгээх.
2. Хуванцар зүйлсээс татгалзах аян, уралдаан, илтгэл зохион байгуулах.

БИ БУЮУ ХУВЬ ХҮН

1. Хуванцар савны хор уршгийг таньж мэдэн аль болох татгалзаж төмөр, шилэн эд зүйлсээр солиж хэрэглэх ба түүнийгээ дадал хэвшил болгох.
2. Мэдсэн зүйлсээ найз нөхөд, гэр бүл, ангийн хамт олондоо түгээн дэлгэрүүлэх.

ДҮГНЭЛТ



Энэхүү судалгааг дүгнэж үзвэл монгол хүмүүсийн дунд нийтлэг хуванцар савны мэдлэг хомс байгааг илтгэж байна. Сүүлийн 25 жилд Монгол Улсын иргэдийн хорт хавдрын өвчлөлийн стандартын төвшин 58 хувиар өссөн байдаг. Гэтэл энэ хугацаанд аюултай хог хаягдал болох хуванцар савыг бид өдөр тутмынхаа

хэрэглээний нэг болгоод хэвшчихсэн. Өөрөө өөрсдийгөө химийн хүнд металлын бохирдолд оруулж, хорт хавдраар өвчлөх үндсэн шалтгаан болж байгаагаа огтхон ч мэддэггүй. Хуванцар савны хэрэглээг халахад хувь хүний ухамсраас гадна төрийн бодлого хэрэгтэй гэж бодож байна. Бид нэг өдөр шийдээд л өөрсдийгөө хүрээлсэн тоо томшгүй хуванцар эдлэлээс бүгдээс нь ангижирч чадахгүй. Харин эрүүл мэндээ хамгаалахын тулд, цаашлаад хүрээлэн буй орчиндоо багахан ч гэсэн эерэг өөрчлөлт гаргахын тулд зарим нэг хуванцрын хэрэглээгээ багасгах бүрэн боломж бий.

Өөрийнхөө эрүүл мэнд болон байгаль орчныг хамгаалахын тулд хуванцар савнаас татгалзаж сурцгаая.

НОМЗҮЙ:

1. www.ubinfo.mn
2. www.trends.mn
3. <http://www.ord.mn/>
4. <https://forms.gle/SmGKAVwRoNG7MJQ18>





ИЛТГЭЛИЙН СЭДЭВ БИДНИЙ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИНД ТУЛГАМДАЖ БАЙГАА АСУУДАЛ

ТҮЛХҮҮР ҮГ:

- ✓ Агаарын бохирдлын хэмжээ
- ✓ Утаа
- ✓ Байглийн үнэ цэнэ
- ✓ Агаарын чанарын индекс

ОРШИЛ

ЭЗЭН ХИЧЭЭВЭЛ ЗАЯА ХИЧЭЭНЭ:

Энэ зүйр цэцэн үг нь хичээж явбал амжилтанд хүрнэ гэсэн үг юм.

Агаарын бохирдол нь зөвхөн Улаанбаатарчуудад бус дэлхий нийтэд хамгийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Үүнээс гарах арга замыг улс орон бүр хайж, тодорхой үр дүнд хүрсээр ирлээ. Үндсэн арга замаа тухайн үйлдэлд хамгийн бага эрчим хүч зарцуулах, байгаль орчинд халгүй эрчим хүч ашиглах гэж тодорхойлдог.

Улаанбаатар хотод хүний амьсгалах түвшинд буй агаарын бохирдлын 90 хувь гэр хорооллын айл өрхийн халаалтын зуухнаас ялгардаг гэх боловч ерөнхий дүнгээрээ дулааны цахилгаан станцууд 90 хувийг ялгаруулдаг. Энэ нь агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нэлээд өргөн хүрээг хамарч явуулах ёстойг харуулж байна. Гол арга зам нь бага хэрэглээгээр илүү тухтай амьдрах явдал бөгөөд үүнд хүрэх үндсэн 3 арга зам байна гэж үздэг.

1. Хэрэглээгээ тогтмол хянаж, үр ашиггүй хэрэглээгээ хязгаарлах;
2. Хэмнэлттэй дэвшилтэт техник технологийг амьдрал ахуйдаа өргөн нэвтрүүлэх;
3. Сэргээгдэх эрчим хүч буюу нар, салхи, усны эрчим хүч, биомассыг түлхүү ашиглах.

Манай орны хувьд агаарын бохирдлын гол эх үүсвэр болох халаалтын эрчим хүчний хэрэглээг бууруулж, үр дүнтэй хэрэглэх боломжийг бүрэн ашиглах хэрэгтэй юм.

ҮНДСЭН ХЭСЭГ:

Агаарын бохирдол үүсдэг шалтгаан:



Агаарын бохирдол гэж хүн ба бусад биетээс шалтгаалсан хувилахуйн болон амин бодисууд, элдэв тоосжилтын нөлөөнд агаар мандалын байгалийн шинж чанар өөрчлөгдөхийг хэлдэг.


Агаарын бохирдлоос шалтгаалан агаарын дээд давхаргад озоны хомсдол бий болж, түүний уршгаар хүн төрөлхтний эрүүл мэнд, дэлхийн эко системд аюул нүүрэлсээр байна.

Агаар байнгын хөдөлгөөнд оршдог тул агаарын

бохирдол нь зөвхөн нэг хэсэг орны төдий биш дэлхий хэмжээний асуудал юм.

Агаарыг бохирдуулагч элдэв төрлийн хий, хатуу хольцууд хүний үйл ажиллагаа (Үйлдвэр түлшний шаталт гэх мэт)-наас үүсэхээс гадна байгалийн замаар үүснэ (Галт уулын дэлбэрэлтээс асар их хэмжээний үнс шороо тоос цацагдана) Агаар дахь хий байнгын эргэлтэд оршиж, үүнд нь ургамал амьтан, ус хөрс, хүний үйл ажиллагаа бүгд оролцоно. Эдгээр замаар агаарт шууд ялгаран орох бохирдуулагчийг анхдагч гэнэ.

Анхдагч бохирдуулагчид хоорондоо болон бусад хийтэй урвалд орсноор шинэ бодис үүсгэнэ. Үүнийг хоёрдогч бохирдуулагч гэж ялгадаг. Агаар дахь хорт хий ихсэх нь хүний эрүүл мэндэд дам төдийгүй шууд нөлөөлдөг явдал цөөнгүй. Агаарын бохирдлыг ихэнх оронд хүхрийн давхар исэл, азотын давхар исэл, озон, тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл зэрэг 6-8 үзүүлэлтээр хянадаг. Харин Монгол улс Улаанбаатар хот болон 20 аймгийн төвийг агаарыг бохирдлыг зөвхөн хүхрийн давхар исэл, азотын давхар исэл хоёроор л хэмжиж байна. Агаарын бохирдол нь хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж амьсгалын замын, зүрх судасны, төв мэдрэлийн системийн өвчлөл, харшлын өвчнүүд, , төрөлхийн гажиг, хавдар зэрэг өвчнүүдийн тархалт, тохиолдлын түвшнийг ихэсгэх, улмаар нөхөн үржихүйн эрүүл мэндийг хордуулах (үр хөврөл гэмтэх, дутуу төрөх), хүүхдийн дархлааг бууруулдаг.



Автомашин утаа хүний амьсгалах түвшинд цацагддаг бөгөөд амьсгалын замын цочмог болон архаг өвчин, харшлын эмгэг үүсгэх, элэг, бөөр, уушгийг гэмтээх, зүрх судас, мэдрэл сэтгэхүйн эрхтнүүдийн үйл ажиллагааг алдагдуулах, амьсгал боох, ядрах бие сульдах, хорт хаальдегид бенз(о)пирен диоксин зэрэг 260 гаруй төрлийн хорт бодис агаарт ялгаруулдгийг эрдэмтэд тогтоожээ.

Тамхи 5-н нас хорооно гэж ярьдаг ч хэрэглэдэг хүмүүс олон. Гэвч зөвхөн татдаг хүмүүс л хорддог мэтээр ойлгох нь өрөөсгөл ойлголт юм.

Зун болохоор утаа маань багасдаг, тийм биз? Тэгтэл та бидний ашигладаг цахилгаан хаанаас ирээд байна вэ? Зурагтаа үздэг, утсаа цэнэглэдэг тэр эрчим хүч хаанаас үүсээд байна?

АГААРЫН БОЛХИРДОЛ ОРДОГ ЭЛЕМЕНТ

- Шингэн [аэрозоль-шингэний жижиг дусал]
- Хатуу [тоос]
- Хий [SO₂,NO,NO₂,CO гэх мэт]
- Агаар бохирдуулагч түгээмэл бодисууд
 - Хүхэрлэг хий [SO₂]
 - Өнгөгүй,өвөрмөц хурц үнэртэй, цочромтгой хий бөгөөд нүүрсний шаталт, тээврийн хэрэгслийн хаягдал утаанаас ихэвчлэн үүсдэг.
 - Азотын ислүүд [NO,NO₂]
 - Шар-хүрэн өнгөтэй, өвөрмөц хурц үнэртэй бөгөөд автотээврийн хэрэгсэл, дизель түлшний шаталт, нүүрсний шаталт, химийн үйлдвэр зэргээс үүсдэг.
 - Тоосонцор [PM_{2.5},PM₁₀] •Агаарт хатуу, шингэн төлөв байдалтай оршдог. Диаметр нь 2,5 микроноос бага хэмжээтэй тоосыг нарийн ширхэглэгт тоосонцор, диаметр нь 2,5-10 микрон хэмжээтэй тоосыг том ширхэглэгт тоосонцор гэнэ. Нүүрс болон тээврийн хэрэгслийн түлшний шаталт, шатаах үйлдвэр, хучилтгүй зам талбай, сул хөрс шороо зэргээс үүсдэг. •Нүүрстөрөгчийн дутуу исэл [CO]
 - Өнгөгүй хий бөгөөд нүүрс болон тээврийн хэрэгслийн түлшний дутуу шаталт, төмөрлөгийн үйлдвэр, шатаах үйлдвэр, машины засвар үйлчилгээний цэг зэргээс ихэвчлэн үүсдэг.

ХҮХРИЙН ДАВХАР ИСЭЛ

Хүхрийн давхар исэл нь хүхэр агуулсан түлшний /нүүрс, дизель/ дутуу шаталт, металл боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааны дүнд үүсдэг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар хүхрийн давхар исэл нэмэгдсэн нь жил бүр 1200 сая хүнд нөлөөлж байна. Хүхрийн давхар ислийн архаг нөлөө нь амьсгалын замын өвчний тохиолдлыг ихэсгэх, уушгины хамгаалах механизмыг бууруулах, зүрх судасны архаг өвчнийг сэдрээх явдал юм. Зүрх судасны өвчтэй болон уушгины архаг өвчтэй хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, өндөр настнууд архаг нөлөөнд өртөмтгий байдаг. Гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс гадаа биеийн хүчний ажил хийж байгаа үед хүхрийн давхар исэлд их өртөмтгий байдаг. Гол нөлөө нь амьсгалын замыг нарийсгадаг ба өртсөн хүнд шуухитнах, цээжээр давчдах, амьсгаа давчдах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Хүхрийн давхар ислийн агууламж маш өндөр байхад эрүүл хүмүүст ч шуухитнах, цээжээр давчдах, амьсгаа давчдах зэрэг шинж тэмдгүүд илэрнэ. Хүхрийн давхар ислийн сөрөг нөлөө зогсоход уушгины үйл ажиллагаа цагийн дотор хэвийн байдалд ордог байна.

АЗОТЫН ДАВХАР ИСЭЛ

Азотын давхар исэл нь авто тээврийн хэрэгслийн дотоод шаталт, цахилгаан халаагуур, цахилгаан станц, химийн үйлдвэр, хог шатаах зуух зэрэг агаар бохирдуулагч эх үүсвэрээс ялгардаг. Азотын давхар исэл нь цочроох үйлчилгээтэй ба амьсгалын замаар орсон хийн 80-90% нь амьсгалын замын салстад шингэдгээс ихэнх нь уушгинд шингэдэг. Иймд азотын давхар исэл нь уушгины эдийг цочроох ба амьсгалын замын халдварт өртөмтгий байдлыг нэмэгдүүлдэг бөгөөд гуурсан хоолойн багтраа болон бронхиттой хүний мэдрэгшлийг ихэсгэдэг. Азотын давхар ислийн архаг нөлөө нь амьсгалын замын өвчний тохиолдлыг ихэсгэх, уушгины хамгаалах механизмыг бууруулах, зүрх судасны архаг өвчнийг сэдрээх явдал юм. Зүрх судасны өвчтэй болон уушгины архаг өвчтэй хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, өндөр настнууд архаг нөлөөнд өртөмтгий байдаг.

ДУЛААРАЛ:

XX зууны уур амьсгалын дулаарлын нэг үндсэн шалтгаан нь хүний үйл ажиллагааны улмаас агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламж ихсэж байгаа явдал юм. Аж үйлдвэрийн хувьсгалаас (1750 оноос эхлэн тоолно) хойш агаар дахь нүүрсхүчлийн хийн агууламж 31%-иар, намгийн хийн агууламж 151%-иар, азотын дутуу ислийн агууламж 16%-иар өсөж, 1930-аад он хүртэл байгалийн нөхцөлд байгаагүй фреоны төрлийн хийнүүд гарч ирснээс дэлхийн уур амьсгалын дулаарал болж байна.

Агаар мандалд хүлэмжийн хийн агууламж ихсэж байгаа нь ой мод огтолсон, газрын хөрс хагалсан, далайн усыг бохирдуулах зэргээс нүүрстөрөгчийн байгалийн эргэлтийн тэнцвэрийг алдагдуулж байгаатай ч бас холбоотой.

ОЗОНЫ ДАВХАРГА

Агаар мандлын дээд давхарга буюу дэлхийн гадаргаас 20-50 км өндөрт байрлах 3-5 орчим мм зузаантай нэг үе давхарга дахь хийн найрлагад хүчилтөрөгчийн гурван атом агуулсан тунгалаг хий хамгийн их хэмжээтэй байх учраас “озоны давхарга” хэмээн нэрлэдэг. Озоны давхарга нь дэлхий ертөнцөд оршин байгаа байгалийн бүхий л амьд бодгаль, ус, ургамал, экосистем, түүний бүрэлдэхүүн, шим мандлыг нарны хамгийн богино долгионтой, хүн амьд биест хортой туяаг дэлхийн гадарга руу нэвтрүүлэхгүй хамгаалж байдаг. Гэтэл, хүний нийгмийн хөгжил дэвшлийн үр дүнд олон төрлийн химийн бодисыг үйлдвэрлэл, ахуй амьдралд хэрэглэн “хүлэмжийн хий”-г агаарт дэгдээх замаар озоны давхаргыг нимгэрүүлэн сиймхий цоорхой үүсгэхэд нөлөөлж буй үзэгдэл нь XX зууны уур амьсгалын дулаарлын хамгийн гол үндсэн шалтгаан гэдгийг эрдэмтэд нотолж, тандан судалгаа явуулж байна. Харин Монгол Улсын газар нутгийн дээрхи агаар мандлын озоны дундаж агууламж 320-360 ДН хэмжээтэй байна гэж тогтоосон.

Антрактид дээр озоны цоорхой үүссэний дараа улс орнууд хуралдаж, Озоны давхаргыг хамгаалах тухай “Венийн Конвенц, Озоны үе давхаргыг задалдаг бодисын хэрэглээг хязгаарлах тухай “Монреалийн Протокол”-д улс орнуудыг нэгдэх тухай хэлэлцэв. Энэхүү конвенц болон протоколд Монгол Улс 1996 онд нэгдэн орж, 1999 оноос Озоны давхаргыг хамгаалах Үндэсний хөтөлбөрийг батлан гаргаж, олон улсын конвенц, хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар үе шаттай арга хэмжээ авч байгаа болно. Дэлхий нийтэд өнөөдөр хлортфторт нүүрстөрөгч (CFC) буюу фреоны үйлдвэрлэл, худалдаа, импорт, экспортыг зогсоож, гидрохлорт нүүрстөрөгч (HCFC)-өөр орлуулж байна. Фреоны озон задлах чадвар 1.0 нэгж буюу хамгийн өндөр байдаг учраас озон задлах чадвараар түүнээс хамаагүй бага буюу 0.055 нэгж чадвартай бодис гидрохлорт нүүрстөрөгчөөр орлуулан хэрэглэх замаар озон хомсдлыг багасгах арга юм. Дэлхийн улс орон бүхэн хэрхэн агаараа цэвэр байлгахын тулд элдэв аргыг бодож сэдэцгээж байна. Жишээ нь: усан хөдөлгүүртэй машин, утаагүй зуух, утаагүй түлш, гэр хорооллыг багасгах, дугуй унах, гэх мэт. Энд АНУ ба Европын бохирдол бодитойгоор багасаагүй харин БНХАУ-ын ихэссэн тооцооллыг тооцоход бусад улсуудынх багассан болж харагдаж байна бодитойгоор бусад улсуудын бохирдол мөн өссөн болно.



Мөн агаарын бохирдолд бас нэг нөлөөлөх хүчин зүйлүүдийн нэг бол: **ТАМХИ** юм.

Тамхины агууламж дахь гол бодис нь **никитон** бөгөөд нэг ширхэг янжуурт 0.1-1.5 мг никотин агуулагдана. 60 мг никотин насанд хүрсэн хүнийг хордуулан амь насыг нь хохироох хэмжээтэй байдаг аж.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

Зун болохоор утаа маань багасдаг, тийм биз? Тэгтэл та бидний ашигладаг цахилгаан хаанаас ирээд байна вэ? Зурагтаа үздэг, утсаа цэнэглэдэг тэр эрчим хүч хаанаас үүсээд байна? Мэдээж манай цахилгаан станцууд ба тэр дотор ажиллаж буй хүмүүс үүнийг жилийн 365 хоног, өдрийн 24 цагийн турш бидэнд хүргэж байдаг.



Улаанбаатар хотын 10,000 хүн амд ногдох амьсгалын тогтолцооны өвчлөл, 5 хүртэлх насны хүүхдийн хатгалгаа өвчин, уушгины архаг бөглөрөл өвчин, 2008-2011 он. Эх сурвалж: ҮСХ Тухайлбал, 2011 оны байдлаар 1289 болж, 5 жилийн өмнөхөөс 1.4 дахин, 10 жилийн өмнөхөөс 1.9 дахин өссөн байна. 10,000 хүүхдэд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн хатгалгаа өвчин 2018 онд хамгийн их буюу 1289, хамгийн бага нь 2,009 онд 692 байна. Харин 10,000 хүн амд ногдох уушгины архаг бөглөрөл өвчнөөр өвчлөгчид 2011 онд 112 болж 3 жилийн өмнөхөөс 5-гоор өссөн байна. 10,000 хүн амд ногдох уушгины архаг бөглөрөл хамгийн их нь 2010 онд 132, хамгийн бага нь 2011 онд 112 байна. Сүүлийн 10 жилийн байдлаар 10,000 хүн амд ногдох хатгалгаа өвчнөөр нас барсан хүн амын тоо харьцангуй тогтмол (1-2) байгаа хэдий ч үүнд 5 хүртэлх насны хүүхдийн хатгалгаагаар нас баралт (3-8) өндөр байсаар байна.

Үүний адилаар бид дэлхийн агаарыг бохирдуулагч орнуудыг судалалаа.

- 2008 онд дэлхийн агаарыг бохирдуулагч гол 5 улс: БНХАУ 23%, АНУ 19%, Европын холбоо 13%, Энэтхэг 6%, ОХУ 6%^[1]
- 2013 онд дэлхийн агаарыг бохирдуулагч гол улсууд: БНХАУ 28%, АНУ 14%, Европын холбоо 10%, Энэтхэг 6.5%^[2]

Энд АНУ ба Европын бохирдол бодитойгоор багасаагүй харин БНХАУ-ын ихэссэн тооцооллыг тооцоход бусад улсуудынх багассан болж харагдаж байна бодитойгоор бусад улсуудын бохирдол мөн өссөн болно.

❖ Хамгий аюултай агаар бохирдуулагчид

Эдгээр нь бага хэмжээтэй ч үхлийн аюултай эсвэл эрүүл мэндэд ноцтой эрсдэлтэй бохирдуулагчид юм. Бараг 200 бохирдуулагчид нь хуулиар цохицуулагддаг. Зарим хамгийн их тархалттай нь мөнгөн ус, хар тугалга, диоксид ба бензол. Эдгээр нь ихэвчлэн хий эсвэл нүүрс шатаах, аливаа шаталт болон бензин агаарт уурших үед ялгарана гэж Валке мөн хэлжээ. Хүрээлэн буй орчныг хамгаалах агентлаг (USA EPA) бензинийг хорт хавдар үүсгэгч төрөлд ангилсан. Энэ нь богино хугацаанд нүд арьсыг цочролд оруулж, урт хугацаанд цусны эмгэгд хүргэнэ. Диоксид нь ихэвчлэн хоол хүнсэнд байдаг ч мөн агаарт бага хэмжээгээр агуулагдаж, богино хугацаанд элгэнд нөлөөлж, мөн дархлаа, мэдрэл, дотоод шүүрлийн систем, нөхөн үржихүйн үйл ажилгааг гэмтээнэ. Их хэмжээний хар тугалга хүүхдийн тархи, бөөрийг аюулд оруулдаг бол бага хэмжээтэй хүүхдийн IQ, сурах чадамжинд нөлөөлнө. Мөнгөн ус хүний төв мэдрэлийн системд нөлөөлдөг байна.

- Полицикл үнэрт нүүрс ус төрөгчид буюу PAHs (polycyclic aromatic hydrocarbons) тээврийн хэрэгслийн яндангийн утаа, хээрийн түймрээс гардаг аюултай бодисууд юм. Их хэмжээний Полицикл үнэрт нүүрс устөрөгчид нүд болон уушигны цочрол, цус болон элэгны асуудал, мөн хорт хавдарт ч хүргэнэ. Сүүлийн үеийн нэгэн судалгаанд, Жирэмсэлэлтийнхээ үед PAHs их өртсөн эхийн хүүхэд тархины сэтгэхүйн урт удаан, Анхаарал Хомсдолын хэт идвэхижлийн эмгэг (ADHD - Attention deficit hyperactivity disorder)-ийн шинж тэмдгүүд илэрсэн байна.

❖ Агаарын бохирдол үүсгэгч хүчин зүйлс

- Сайжруулсан түлш
- Электрон тамхи
- Янжуур тамхи
- Ургамалийн гаралтай тамхи
- Авто тээврийн хэрэгсэл
- Дулааны цахилгаан станц
- ✓ АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ: Насжилтын хувьд ямар байгаа вэ? Улаанбаатар хотод 2009-оны 6-р сарын байдлаар 120000 орчим тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байна
- ✓ .2000-2008 он хүртэл найман жилийн хугацаанд тээврийн хэрэгсэлийн тоо жилд ойролцоогоор 51000-аар өсч ирсэн. Улаанбаатар хотын хэмжээнд ерөнхийдөө 10-аас дээш жил ашиглагдсан тээврийн хэрэгсэл зонхилж байгаа. Гэхдээ сүүлийн жилүүдэд шинэ авто машины тоо бага бага багаар нэмэгдэж байна.

- ✓ Электрон тамхи: Электрон тамхийг 2003 онд Хятадад бүтээжээ. Уламжлалт тамхинаас ялгаатай нь хэрэглэгч утаа биш уур сорно. Өөрөөр хэлбэл шингэнийг уур болгон сордог байна. Ангилиар varог гэх бөгөөд вейп гэх нэршил үүсэж, татах үйл явцийг вейпинг гэж нэрлэх болсон байна. Электрон тамхиар хорт хавдар үүсгэдэг химийн бодисууд агуулагддаг. Харин электрон тамхи буюу вейпийг тамхи хаях гэж байгаа хүмүүст зориулан үйлдвэрлэдэг гэх яриа байдагч энэ нь том төөрөгдөл аж. Учир нь электрон тамхи нь уламжлалт тамхинаас ялаагүй никотин болон хорт хавдар үүсгэдэг химийн хорт бодисууд агууладаг гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын албан ёсны сайтад бичжээ. Зарим газар 21 хүрээгүй насанд хүрээгүй хүүхэд зарснаас болоод тэр хүүхдийн бие махбод болон хажууд нь байгаа хүүхэд хүртэл хордож байна.

Утаанд байх химийн бодис түүний биед үзүүлэх хорт нөлөө

Зөвхөн нэг өдөрт л гэхэд нийслэл хотын агаар мандалд одоо явж буй 40 гаруй мянган тээврийн хэрэгслээс 80 гаруй тонн хорт бодис цацагддаг. Энэ нь агаарын бохирдлын 30 хувийг эзэлж байна. Манайд Европ, Азийн хог дээр хаягдах шахсан хуучин машинууд "ясаа" тавьдаг болохоор тэдгээрийн хүрээлэн буй орчиндоо хаяж буй хорт бодисын хэмжээ жилээс жилд улам ихэссээр байна. Хуучин машины утаа хорт бодисыг илүү ихээр ялгаруулдаг ажээ.

Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс ялгаран гарч буй утааны найрлаганд нүүрстөрөгчийн исэл, хөө тортог, хар тугалга, бензипирэн, альдегид зэрэг 200 гаруй хорт бодис байдаг аж. Эдгээр нь хүнийг амьсгалахад дотор эрхтэнд нь шууд тархаж, цусны улаан эсийн солилцох чадварыг алдагдуулдаг юм байна. Үүний улмаас хүчилтөрөгчийн дутагдал орж төв мэдрэлийн системийн үйл ажиллагаа алдагдан, бие сулрах, толгой өвдөх, дотор муухайрах, бөөлжис цутгах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг ажээ. Агаарын найрлага дахь азотын хэмжээ ихэссэн орчинд амьдарч буй хүүхдийн цусны бүтцийн үзүүлэлтүүд өөрчлөгдөж, амьсгалынх нь үйл ажиллагаа мууддаг болохыг дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас мэдээлжээ.

Мөн хүхэрлэг хий нь хамар болон нүдний салст бүрхэвчийг цочроож, уургийн солилцоо, дааврын үйл явцыг алдагдуулж, уушгинд муу нөлөө үзүүлдэг байна.

АГААРЫН БОХИРДОЛЫГ БУУРУУЛАХ АРГА ЗАМ



Улаанбаатар хотод хүний амьсгалах түвшинд буй агаарын бохирдлын 90 хувь гэр хорооллын айл өрхийн халаалтын зуухнаас ялгардаг гэх боловч ерөнхий дүнгээрээ дулааны цахилгаан станцууд 90 хувийг ялгаруулдаг. Энэ нь агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нэлээд өргөн хүрээг хамарч явуулах ёстойг харуулж байна. Гол арга зам нь бага хэрэглээгээр илүү тухтай амьдрах явдал бөгөөд үүнд хүрэх үндсэн 3 арга зам байна гэж үздэг.

1. Хэрэглээгээ тогтмол хянаж, үр ашиггүй хэрэглээгээ хязгаарлах;
2. Хэмнэлттэй дэвшилтэт техник технологийг амьдрал ахуйдаа өргөн нэвтрүүлэх;
3. Сэргээгдэх эрчим хүч буюу нар, салхи, усны эрчим хүч, биомассыг түлхүү ашиглах.

ЯНЖУУР ТАМХИНИЙ СУДАЛГАА:

2018 оны судалгаагаар манай улсын 15-64 насны дөрвөн хүн тутмын нэг нь буюу нийт хүн амын 27 хувь нь тамхи татдаг хэмээх тоо гарчээ. 2020 оны жилийн эцсийн тайлангаар манай улс нийт 21 улсаас 3 тэрбум ширхэг янжуур тамхийг 60 сая ам.доллар буюу 172.5 тэрбум төгрөгөөр импортолжээ. Дэлгүүрт дотоодын янжуур 2800 төгрөгөөр зарагдаж буй 2010 төгрөгийн үнэтэй хайрцаг тамхинаас жилд 65.5 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц хэмжээг борлуулсан гэхээр нийт 32 сая хайрцаг буюу 640 сая ширхэг янжуур борлуулсан байх нь. Үүнийг импортын янжуур дээр нэмбэл нийт 3 тэрбум 640 сая ширхэг болж байна. Тамхины хяналтын тухай хуулийн 6.7.2-д янжуурыг нэг хайрцагт 20 ширхгээс цөөнөөр савлахыг хориглосон тул хайрцаг тамхи дахь ширхгийн тоог 20-оор тооцов/

Хайрцаг тамхины үнийг доторх тоо ширхэгтэй нь харьцуулж үзвэл нэг ширхэг дотоодод үйлдвэрлэсэн янжуур 102 төгрөг, харин импортын янжуур 58 төгрөгийн үнээр үйлдвэрээс гардаг аж. Үүндээ жилд үйлдвэрийн үнээр нь тооцвол дунджаар 1.2 сая төгрөгийг /334 хайрцгийг импортын тамхиар бодвол 1.5 сая төгрөг.

ДҮГНЭЛТ:



Агаарын бохирдол гэдэг нь хүн ба бусад амьд биетээс шалтгаалсан бодисууд, элдэв тоосжилтийн нөлөөнд агаар мандалын байглийн шинж өөлчлөгдхийг хэлдэг юм -байна. Тэгвэл 2008-2011 оны агаарын бохирдол хэрхэн өөрчлөгдснийг судалгаан дээрээс харцгаая. Өнгөрсөн 2008-2010 онд Улаанбаатар хотын оршин суугчдын дунд амьсгалын замын өвчин асар хурдтай нэмэгдэж, 10,000 хүн тутамд амьсгалын замаар халдвар авах тохиолдлууд 2.7-дахин нэмэгдсэн. Монголд өвөл зуны хооронд тэмдэглэгдсэн үр зулбалт 3.5-дахин нэмэгдэж байна.

ЦЭНХЭР ТЭНГЭРТ ЦЭВЭР АГААР

АМЬСГАЛЖ БУЙ АГААР НЭГ АГААРАА ХАМГААЛЖ АМЬДАРЛАА
ХАМГААЛЦГААЯ.



ИЛТГЭЛИЙН СЭДЭВ НОМТОЙ НӨХӨРЛӨЕ КЛУБ БАЙГУУЛАХ НЬ

ЗОРИЛГО:

Оюутан сурагчдыг номтой нөхөрлүүлэх ,чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, ном унших хүсэл сонирхлыг төрүүлэх ,номоор дамжуулан амьдралын арга ухааныг олж авахад туслах.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ:



Ном унших дадал харвардын дипломоос илүү
“Билл Гейтс”

- Бид чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхийн тулд юу хийх боломжтой вэ?
- Сургуулийн орчинд хийх боломжтой зүйл юу вэ?
- Бид цахим орчноос хэрхэн холдох вэ?
- Бид өөрсдийгөө хичээлээс гадуур сонирхолтой байдлаар хэрхэн хөгжүүлж болох вэ?
- Хамтран хөгжих бие биенээсээ суралцах боломж хэр байна вэ?

Эдгээр асуултуудыг судалж, хариулж шийдвэрлэхийн тулд “ Номтой нөхөрлөе клуб байгуулах нь “ сэдвийг сонгож авлаа.

Зорилго:Оюутан сурагчдыг номтой нөхөрлүүлэх ,чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, ном унших хүсэл сонирхлыг төрүүлэх ,номоор дамжуулан амьдралын арга ухааныг олж авахад туслах

Судалгааны арга:

1. Асуулгын арга
2. Нэгтгэн дүгнэх
3. Ажилглалтын арга
4. Таамаглал дэвшүүлэх арга

Судалгааны хамрах хүрээ:

ҮҮПК-н оюутан сурагчид

Судалгааны ач холбогдол:

Сургуулийн сурагчдын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, суралцагчдын хоорондын харилцааг сайжруулах, бие биенээсээ суралцах боломжийг бий болгох, ном унших зөв дадал төлөвшилтэй болгох ач холбогдолтой юм

ОРШИЛ.**Ном унших шалтгаан****1.ТӨВЛӨРӨХ ЧАДВАР ХӨГЖДӨГ**

Ном унших хамгийн тохиромжтой байрлал бол ор, ариун цэврийн өрөө, хоолны ширээ байдаг байна. Ном их уншсан хүмүүсийн өндөр цалин авах, сонгосон мэргэжилдээ амжилт олох, нийгмийн асуудлыг ойлгож, оролцох, зорилгодоо хүрэх, нухацтай байх чадвар нь бусад ном уншдаггүй хүмүүстэй харьцуулахад илүү өндөр үзүүлэлттэй байдаг нь тогтоогдсон. Судлаачдын үзэж байгаагаар ном унших нь төвлөрөх, анхаарлаа хандуулах чадварыг бусад хүчин зүйлээс илүү сайн хангаж чаддаг байна.

2. ҮГСИЙН САН НЭМЭГДДЭГ

Унших явцдаа бид маш олон мэдэхгүй үг, өмнө нь сонсож байгаагүй хэллэг, шинэ хэлцүүдийг сурж байдаг. Тэдгээр үгийг мэддэг болсноор өдөр тутмын амьдралдаа хэрэглэж, санаа бодол бичвэртээ хүртэл шингээх нь бий. Телевизийн нэвтрүүлэг үзсэнээс 50 хувь илүү үгийг ном ашигладаг. Үгсийн сангаа сайжруулснаар бичих чадвараа ч сайжруулж байгаа юм.

3.ОЙ САНАМЖ САЙЖИРДАГ

Ном уншсанаар зохиолын дүрүүд, үйл явдлууд, өнгө аяс, гол утга санаа, нөхцөл байдал гэх мэт маш олон зүйлийг санах хэрэгтэй болдог. Эдгээр нь таны оюун санаанд шинэ төрлийн ой санамжийг үүсгэж богино хугацааны санах ой, тогтоох чадварыг тань сайжруулдаг.

4.ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЧАДВАР НЭМЭГДДЭГ

Уншиж дууссан номынхоо утга санаа, гол дүрүүдийн үүрэг, сэтгэл хөдлөл, мэдрэмжүүдийг таньж мэдэхийг оролдох нь таны задлан шинжлэх, уншаад ойлгох чадвар болоод бусдыг ойлгож сурахад тань нэн тустай юм.

5.ХАРИЛЦАХ ЧАДВАР САЙЖИРДАГ

Ярьж байхдаа өөртөө итгэлтэй байхад тань ном тусална. Ном уншиж үгсийн сангаа баяжуулснаар хүмүүст өөрийгөө тодорхой, ойлгомжтой илэрхийлж чаддаг. Мөн хамгийн шилдэг ярианы сэдвийн сонгодог жишээ бол ном шүү дээ.

5.ТАРХИНЫ ДАСГАЛ БОЛДОГ

Тархи яг л булчин шиг. Хэрвээ та энэ булчинг дасгал хийж хөгжүүлж чадвал оюун ухааныхаа хүчийг (оюуны чадамж) сайжруулж болно. Байнга ном уншиж тархиа дасгалжуулж байсан хүмүүсийн тархины доройтол буюу зөнөх өвчин тусах магадлал 32 хувиар бага байдаг.

7.МЭДЭЭЛЭЛ БОЛОН МЭДЛЭГЭЭ НЭМЭГДҮҮЛНЭ

Ном унших нь шинэ зүйл турших, хоббигоо хөгжүүлэх боломжийг олгодог. Магадгүй “Наруто”-г уншиж байгаад Японы соёлоос суралцах хүсэлтэй болох эсвэл “Франкенштейн”-ыг уншаад шинжлэх ухааныг сонирхох ч юм бил үү?

8. СТРЕССИЙГ БУУРУУЛЖ СЭТГЭЛ САНАА САЙЖИРДАГ

Судлаачдын үзэж байгаагаар ном унших нь стрессийг 68 хувиар бууруулдаг байна. Сэтгэл гутрах өвчнөөр өвчлөгчдийн өөртөө туслах хамгийн сайн арга нь мөн л ном байдаг бөгөөд чанга дуугаар ном уншихад сэтгэл гутрах өвчнөөр өвчлөгчдийн сэтгэцэд



эерэг ахиц гарч байгаа нь ажиглагджээ.

9. БҮТЭЭЛЧ БАЙДАЛ ХӨГЖДӨГ

Биднийг уйтгар гунигаас зайлсхийхэд, бүтээлчээр сэтгэхэд, хөгжилтэй, адал явдал дүүрэн байж чадах боломжийг ном л өгдөг шүү дээ. Зохиолын дүрүүдээс, тэдний асуудлаа шийдсэн туршлагаас, шинжлэх ухааны баримтаас, магадгүй зохиолчийн амьдралаас бид амьдралдаа хэрэгжүүлж болох маш олон бүтээлч санааг сурдаг.

10. ТӨСӨӨЛӨХ ЧАДВАР САЙЖИРДАГ

Уншигч байх нь төсөөлөх чадварыг сайжруулдаг. Унших нь таныг шинэ ертөнцийг нээхэд тусалдаг. Өөр улс оронд, зохиомол ертөнцөд, өнгөрсөн болоод ирээдүйд, түүнээс ч илүүд хэрэн тэнэхэд тусална.

11. АЛДААГҮЙ ЗӨВ БИЧНЭ

Одоо цагт өөрчлөгдөж байгаа түм буман үгсийн жагсаалтыг цээжлэхээсээ урьтаж дуртай номоо уншингаа зөв бичих чадвараа сайжруулж болох бөгөөд дараагийн удаа тухайн үгийг хэрэглэхдээ өөрийн мэдэлгүй л зөв бичиж чаддаг болсон байх болно. Мөн эссэ, зохион бичлэг, өгүүлэл, тайлангаас эхлээд бичгийн ажил дээр ажиллах чадвар тань мэдэгдэхүйцээр ахиц дэвшилтэй байх ба энэ нь таны үгийн сангийн баялаг, төсөөлж ургуулан бодох чадвар, өөрийгөө товч тодорхой болоод эмх цэгцтэй, утгын зөв дэс дараалалтай илэрхийлэх чадвар зэрэг номноос олж авсан бүхий л чадварын тань илэрхийлэл билээ.

Ном уншихын ач тус

- ✓ Ном унших нь хүний танин мэдэхүйг хурцалж ухааныг тэлдэг

Та өөрийгөө болон хүрээлэн буй орчин хүмүүсийг илүү ихээр ойлгож хардаг болох бөгөөд хамгийн чухал нь өөрөө өөрийгөө таньж мэдэх болно. Сайн номыг заавал ахин унш. Тэндээс та ямар нэгэн шинэ зүйлийг олж харах болно.

- ✓ Ном унших нь таны эрүүл мэндэд тустай

Уйгагүй бүгдийг дуустал уншиж түүнийгээ бодитойгоор сэтгэж, үүгээрээ зохиолч юу хэлэх гээд байгаад дүгнэлт хийж, өөрийн бодол тайлбарыг хийх зэрэг нь оюуны дасгал болдог. Энэ нь таны эрүүл мэндэд үнэ төлбөргүй оруулж буй хөрөнгө оруулалт юм.

- ✓ Ном унших нь орчин тойрондоо эерэгээр нөлөөлдөг

Хэрэв та ном уншиж байвал цаг зав чинь дэмий зүйлд зарцуулагдаагүй гэсэн үг. Ном унших нь компьютер ашигласанаас хялбар юм. Та ном уншиж байна гэдэг нь элдэв дугаарлал түгжрэлийг багасгаж, гудамгаар хий хоосон сэлгүүцэхгүй, машин барьж агаар бохирдуулахгүй байна гэсэн үг.

- ✓ Ном унших нь таныг харилцаанд сургана

Та ярилцах явцдаа өчигдөрийн спортын үйл явдлын талаар телевизийн нэвтрүүлэгийн тухай ч юм уу өөр ямар нэгэн зүйлрүү ярианыхаа сэдвийг гэнэт өөрчилж чадаж байвал таны ярих авьяас чинь хөгжиж төсөөлөн буй зүйлээ хялбархан илэрхийлж чаддаг болж байна. гэсэн үг. Ялангуяа энэ нь бараг ном уншдаггүй хүмүүст илүү их өндөр сэтгэлдэл төрүүлнэ.

- ✓ Ном унших нь чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрөөхөд тустай

Ном нь олон төрөл байдаг тул та хэзээ ч бүгдийг уншиж амжихгүй. хэрэв бүгдийг уншиж дуусгая гэхэд хүний амьдралын хэд хэдэн үе ч хүрэлцэхгүй. Маш олон төрлийн номноос сонголт хийж уншиж болох боловч өөртөө хамгийн их хэрэгтэй гэсэн үнэхээр сэтгэлийн ханаж авч болох тэр л номоо сонгон унш. Үүнийгээ олтол бүү шантар. Тэр амьдралыг чинь өөрчилж мэднэ.

- ✓ Ном унших нь амар амгаланг бий болгоно

Багш нар, эцэг эхчүүд, насанд хүрэгчид хэн боловч ном уншиж байгаа хүүхдийг хараад хайр нь хүр ч сэтгэлийн баяр эдэлдэг бөгөөд дараагийн удаа түүнийг яасан ч зэмлэдэггүй гэнэ.

✓ Ном унших нь таны мөнгөнд хэмнэлттэй

Ном нь цахим тоглоомоос хямд. Хэрэв ном унших дуртай бол таньд найз нөхөд чинь бэлэг сонгохдоо ямар ч эргэлзээгүй дуртай номыг тань сонгоно. /Таньд анхаарах ганц зүйл хэрэгтэй номынхоо жагсаалтыг гаргасан байх хэрэгтэй. Энэ нь таньд ашигтай. Ном унших дуртай хэнд ч номын сангууд нээлтэй. Тэнд та ямар ч мөнгө төлөхгүй ном уншиж болно.

✓ Ном унших нь оюун ухаанаа төвлөрүүлэхэд тустай


Хөгжим сонсож байхдаа ч юмуу ер нь хаа ч явсан эргэн тойрныхоо зүйлд анхааралаа сарниулахгүйгээр ном уншиж болдог. Туршлагатай уншигч телевизийн 4 суваг сольж үзэж байхдаа уншиж чаддаг байна. Хэрэв та өөрөө хүсэх л юм бол автомашин болон нийтийн тээврээр зорчиж байхдаа ч ном уншиж чадна.

✓ Ном унших нь таны гадаад үзэмжинд эерэгээр нөлөөлдөг

Илүү жинтэй болохоос битгий айцгаа. Ном их уншдаг хүн амьдралд тохиолдох хүнд бэрхийг давж гарах сэтгэлийн тэнхээтэй болдог бөгөөд бусдыг бодвол арай хөнгөн байдлаар бэрхшээлийг туулж гардаг. Номтой нөхөрлөснөөр та оюун сэтгэхүйгээрээ уран зөгнөлт хүсэлдээ хөтлөгдөн бодол ухаанаараа хязгааргүй орчинд аялан явж чадна. Мөн таны оюун сэтгэхүйд номын үйл явдлууд кино мэт хөврөн үзэгддэг болохоор кино театр попкорн идэж суух ямар ч шаардлаггүй болно.

✓ Ном унших нь эцэг эхчүүдэд ашиг тустай


Хүүхэд хэрхэн ном уншиж түүнд автаж байгааг хараад ажил ихтэй ном унших завгүй хүмүүс хүртэл түүнд татагддаг. Ном уншихын жаргалыг мэдрүүлж байр баясгалан авчирсан уншигч хүүхдүүдээ эцэг эхчүүд нь ахин талархах болно



Сургуулийн номын сангийн номны ихэнх хувийг сурах бичиг эзэлдэг бөгөөд бидэнд уншихад тохиржтой, уншихыг хүссэн сонирхолыг татахуйц ном байдаггүй Энэхүү клубыг байгуулснаар Оюутан сурагчид чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэн амьдралийн зөв дадал хэвшилтэй болно.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ: ОЮУТАН СУРАГЧДААС АВСАН СУДАЛГАА \108 СУРАГЧ\

Чөлөөт цагаараа юу хийдэг вэ?



Чөлөөт цагаараа юу хийдэг вэ?


Facebook үздэг-46

Ном уншдаг-18


Дугуйланд явдаг-12

Бусад-31

Та ном уншдаг уу?



Сургуульд таны уншихыг хүссэн ном байдаг уу?




Сургуульд таны уншихыг хүссэн ном байдаг уу?

Байдаг-4

Байдаггүй-104

Сургуульд номтой нөхөрлө клуб байгуулахыг юу гэж бодож байна вэ? Дэмжиж байна уу?



Сургуульд номтой нөхөрлө клуб байгуулахыг юу гэж бодож байна вэ? Дэмжиж байна уу?

Дэмжиж байна-70

Дэмжихгүй байна-4

Мэдэхгүй байна-34

КЛУБЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Ном уншин номын тэмдэглэл хөтлөх
- Уншсан номын тухай ярилцлага зохиох , Мэдээлэл солилцох
- Facebook групп идэвхтэй хөтлөх
-

Номын тэмдэглэл хөтлөх

Номын тэмдэглэл хөтлөх гэдэг нь уншсан номынхоо гол утга санаанд өөрийн бодлоо тусган эргэцүүлэл хийх юм.

Давуу тал:

- Бичгийн хэв сайжирна
- Зохион найруулах ур чадвар хөгжинө
- Мэдээллийг боловсруулж сурна
- Бүтээлч чадвар хөгжинө
- Сэтгэн бодох чадвар хөгжинө
- Анхаарлаа төвлөрүүлж сурна



ДҮГНЭЛТ

Сурагчид чөлөөт цагаа зөв боловсон өнгөөрөхөд тусална.Сурагчид ном унших дадалд суралцана.Сурагчид бие биетэйгээ мэдээлэл солилцох боломж нэмэгдэж харилцаа сайжирна.Мэдээллийг боловсруулж дүгнэж сурна.



ИЛТГЭЛИЙН СЭДЭВ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД НБД-ЫН ҮҮРЭГ ОРОЛЦОО

ҮНДЭСЛЭЛ

Өөдлөх айл үүд хаалганаасаа гэдэг шиг танай байгууллагын амжилт мэргэжлийн түвшинд ажил үүргээ гүйцэтгэх нарийн бичгийн даргаас эхлэх болов уу



Нарийн бичгийн дарга гэдэг энэ мэргэжлийг өмнө нь зөвхөн тушаал хүлээн авагч, ганц нэг цаас үйлдэж хэн нэгэн, албан байгууллагад дамжуулах, эсвэл зөвхөн цай, кофе зөөх төдийнхөөр төсөөлдөг байсан.

Тэгвэл энэ үе нэгэнт өнгөрч энэ асуудал өнөөдөр мэргэжлийн түвшинд яригдах болсон. Өө үед НБД-ын ажлын цар хүрээ улам өргөжиж байна.

Нөгөө талаас баримт бичигтэй харилцдаггүй, баримт бичиг боловсруулдаггүй ямар ч байгууллага байхгүй.

Иймээс тухайн байгууллагын үйл ажиллагаанд Нарийн бичгийн дарга мэргэжлийн үүрэг оролцоо яагаад чухал болох, энэ мэргэжлийн шаардлага, эрэлт хэрэгцээ байгаа эсэх, энэ мэргэжлээр суралцагчид цаашид юуг анхаарах шаардлагтайг тодруулах үүднээс энэхүү сэдвийг сонголоо.

Онолын хэсэг:

Нарийн бичгийн дарга юу хийдэг вэ? Нарийн бичгийн дарга мэргэжил хэрэгтэй юу? Нарийн бичгийн даргаар амжилттай ажиллаж, чадах уу?

Нарийн бичиг нь даргын сайн туслагч байхаас гадна байгууллагын хэмжээнд үүсч хөтлөгдсөн баримт бичигтэй ажиллах үндсэн үүрэгтэй юм.

Баримт бичгийг стандартын дагуу боловсруулах.

Байгууллагад ирсэн, явсан баримт бичгийг бүртгэх

Мэдээллийн болон харилцагчийн нууцыг хадгалах, хамгаалах

- Компьютерийн чадварууд
- Удирдах, удирдуулах

Дүр төрх

Нарийн бичгийн дарга ямар сэтгэгдэл төрүүлэх ёстой вэ?

Сэтгэл цэмцгэр	татам	Цэвэр	Өөртөө итгэлтэй	Энгийн Даруухан Төлөв
-------------------	-------	-------	--------------------	--------------------------

Байгууллагын үйл ажиллагаанд Нарийн бичгийн даргын гүйцэтгэх үүрэг оролцоо, энэ мэргэжлээр суралцахад анхаарах зүйлсийг тодруулах, дүн шинжилгээ хийх төдийгүй Үйлдвэрлэл Урлалын Политехник коллежийн суралцагчдад энэ мэргэжлийн давуу тал, онцлогийг таниулахыг зорилоо.

Судалгааг GOOGLE FORM програм ашиглан авсан болно.

Судалгааг 2 хэсгээр авч нэгтгэсэн болно.

Байгууллагаас /асуулгын аргаар/

Суралцагчаас /түүврийн аргаар/

Байгууллагаас

Энэ мэргэжлийн нийгмийн эрэлт хэрэгцээ шаардлагыг тодруулахаар НБД-ын ажлын байрны судалгааг нийт 30 гаран байгууллагаас авсан болно.

Танай байгууллагад НБД мэргэжил байдаг уу, зайлшгүй шаардлагатай юу? гэсэн асуултанд:



Танай байгууллагад НБД мэргэжил байдаг уу? гэсэн асуултанд 90 гаруй % нь зайлшгүй шаардлагатай гэсэн бол 5% нь тийм ч чухал биш 5% нь байдаггүй гэсэн байна.


Энэ нь байгууллагуудад НБД мэргэжлийн орон тоо шаардлагатай гэдэг нь харагдаж байна. Нөгөө талаараа НБД мэргэжил нь салбар харгалзахгүй ажиллах боломжтой байдгаараа онцлог юмаа. Өөрөөр хэлбэл боловсрол, уул уурхай, эрүүл мэнд, аялал жуулчлал гээд бүхий л

салбарт энэ мэргэжил байдаг.

Мэргэжлийн сургуулийн “Нарийн бичгийн дарга” мэргэжлээр төгсөгчдөөс ажилд авах боломж хэр байдаг вэ


Боломжтой 50%, боломжгүй 20%, хувь хүнээс шалтгаална 30% гэсэн байна. Ажил олгогч байгууллагууд их дээд сургууль төгсөгчдийг ажилд авах сонирхолтой байдаг нь харагдаж байна.

Гэхдээ хувь хүнээс шалтгаалаад мэргэжлээрээ ажиллах бүрэн боломж байгаа.



Суралцагчидаас /асуулгын аргаар/


Энэ мэргэжлийг сонгон суралцахад юу хамгийн ихээр нөлөөлсөн бэ?



- Эцэг эх, гэр бүл – 40%
- Найз нөхөд – 15%
- Өөрийн сонирхол – 30%
- Мэдээллийн хэрэгсэл – 15%

Үүнээс үзэхэд МСҮТ-д суралцахад гэр бүл ихээхэн нөлөөлсөн болох нь харагдаж байна.

Төгсөөд мэргэжлээрээ ажиллах уу?




- Тийм – 40%
- Үгүй - 20%
- Сайн мэдэхгүй – 35%

Үүнээс үзэхэд суралцагчид мэргэжлээрээ ажиллах сонирхол байгаа нь харагдаж байгаа ч одоохондоо сайн мэдэхгүй байна гэж олон хүүхэд хариулсан байна.

Эргэлзэж байгаа энэ хүүхдүүдийг ажиллах сонирхолтой болгож өөрчлөх, мэргэжилдээ дуртай сонирхолтой болгох зайлшгүй шаардлагтай байна.

Энэ мэргэжлээр суралцахад бэрхшээлтэй зүйл юу байна вэ?



Бэрхшээлтэй зүйл байдаггүй гэж – 60%, залхуурах, гэрийн даалгавар хийдэггүй гэх мэт өөрийн зүгээс шалтгаалах бэрхшээл – 30%, ар гэрийн асуудал болон зарим хичээлээ сайн ойлгодоггүй гэж 10% нь хариулсан байна.

Үүнээс харахад энэ мэргэжлээр суралцахад бэрхшээлтэй зүйл төдийлөн байдаггүй юм байна.

ДҮГНЭЛТ



- Олон улсад гүйцэтгэх нарийн бичгийн дарга нь засаг захиргааны шатлалд өндөр албан тушаалд багтдаг. Жишээ нь Пакистанд холбооны нарийн бичгийн дарга нарыг тус улсын хамгийн нөлөө бүхий хүмүүс гэж үздэг.
- Үүнээс үндэслээд дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргэж байна.

1. Байгууллагуудаас авсан судалгаанаас харахад НБД мэргэжил зайлшгүй шаардлагтай гэдэг нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл: төрийн хувийн

мөн аль ч салбарын байгууллагад энэ мэргэжлийн орон тоо байгаа нь давуу тал болж байна.

Тодруулбал:

Баримт бичиг боловсруулдаггүй, баримт бичигтэй харилцдаггүй ямар ч байгууллага байхгүй. НБД мэргэжлийн нэг үндсэн үүрэг нь баримт бичигтэй ажиллах байдаг.

Нөгөө талаас байгууллага бүр удирдлага буюу дарга, захиралтай байдаг. НБД мэргэжлийн бас нэг үүрэг нь даргын ажлыг хөнгөвчлөх, үйл ажиллагаанд нь туслах, маш сайн хамтрагч буюу баруун гар нь байдаг.

Баримт бичгийн стандарт, албан хэрэг хөтлөлт, архивын хууль, заавар, журам гээд маш олон баримт бичгүүд байгууллагын үйл ажиллагаанд хөтлөгддөг. Үүнтэй холбоотойгоор байгууллагууд мэргэжлийн хүн ажиллуулах шаардлагтай болсон байна.

Байгууллагууд НБД нь мэргэжлийн ур чадвартай байхаас гадна харилцааны соёл, зан ааш, цаг баримтлах, хүнтэй зохицож ажиллах чадвар, сэтгэл гээд хувь хүний хандлага, хүмүүжлийг чухалаар авч үздэг.

Ажлын байрандаа зохицож ажиллахын нэг гол үндэс нь багаар ажиллах байдаг бөгөөд үлангуяа НБД хүн даргатайгаа, ажилчидтай, үйлчлүүлэгчидтэй, гаднаас ирсэн зочид төлөөлөгчидтэй хамтран ажиллах ажлын арга барилыг заавал эзэмших ёстой.

Мэргэжил сонголтонд гэр бүлийн нөлөө их байдаг нь харагдаж байна. Тиймээс эцэг эхтэй сайн хамтран ажиллах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энэ сургуулийг энэ мэргэжлийг сонгоход нь нөлөөлсөн шиг амжилттай сайн суралцахад нь мөн төгсөөд мэргэжлээрээ ажиллахад нь ч бас нөлөөлөх ёстой.

Ямар ч л байсан энэ мэргэжлийн сонгоод ороод ирсэн хүүхдүүдийг мэргэжилдээ дур сонирхолтой болгох цаашлаад өөрийн эзэмшсэн мэргэжлээрээ ажиллана гэсэн бүрэн дүүрэн итгэлийг төрүүлэх зайлшгүй шаардлагтай байна. Үүнд багшийн, сургуулийн, эцэг эхийн, өөрийн зүгээс юуг анхаарах шаардлагтайг тодруулах.

“Дуудах нэрийг эцэг эх өгнө, дуурсах нэрийг өөрөө олж авна”